



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

02.07 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 1/270

Улаанбаатар хот

Г Журам шинэчлэн батлах тухай Г

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 4.3.8.4 дэх заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журам"-ын шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталж, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. Тушаал батлагдсантай холбогдуулан МУИС-ийн захирлын 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/52 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээний хэлтсийн дарга (С.Должин), бүрэлдэхүүн сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

1422062143



Захирлын 2022 оны 01 дугаар сарын 01 -ны
өдрийн 11/11/2022 дугаар тушаалын хавсралт

МУИС-ИЙН СУДАЛГААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ

НЭГ. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журам МУИС 2016-2024 оны стратегийн төлөвлөгөөндөө “Судалгааны хамрах хүрээг өргөжүүлэх, судалгааны түвшнийг дэлхийн жишигт нийцүүлэх”-ээр тэргүүлэх чиглэлээ тодорхойлж, судалгааны их сургууль болон хөгжих зорилт тавин ажиллаж буйтай холбогдуулан судлаач, багш, оюутнуудын судалгааны үйл ажиллагааг дэмжих, эрдэм шинжилгээний бүтээлийн түвшин, эрдэм шинжилгээний гадаад, дотоод хамтын ажиллагааг нэмэгдүүлэх харилцааг зохицуулна.

1.2 Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, мөн МУИС-ийн холбогдох дүрэм, журамд нийцүүлэн энэхүү журмыг баримтална.

1.3 Судалгааны санхүүжилтийг профессор багш нар болон докторын зэрэгтэй залуу багш нарт суурь зардал хэлбэрээр олгох, салбар дамнасан судалгаа хийх залуу судлаачдын багт тэтгэлэг олгох, МУИС-ийн профессор багш нартай хамтарсан судалгаа хийж, үр дүнгээ нийтлүүлэх судлаачдад судалгааны тэтгэлэг олгох (fellowship institute), өндөр түвшний судалгаа болон инновацийн төслийн үр дүнг нийгэм эдийн засгийн эргэлтэд оруулах, их сургуулийн судалгааны тэргүүлэх чиглэлийн бодлогын судалгааг дэмжих зэрэг үйл ажиллагаанд зарцуулна.


1.4 МУИС-ийн үндсэн орон тоонд ажиллаж буй профессор, дэд профессор, ахлах багш, докторын зэрэгтэй эрдэм шинжилгээний ажилтан нар төслийн санал мэдүүлнэ.

1.5 Судлаач нь Шинжлэх ухаан технологийн сан, Азийн судалгааны сан, МУИС-ийн захиалгат, МУИС-ийн судалгааны санхүүжилттэй төслийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд төслийн сонгон шалгаруулалтад өрсөлдөх эрхгүй.

1.6 МУИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор, ахлах багш, докторын зэрэгтэй эрдэм шинжилгээний ажилтны гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлсэн дотоод төслүүдийн сүүлийн 5 жилийн санхүүжилтийн нийлбэр дүн 100 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.

1.7 МУИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор, ахлах багш, докторын зэрэгтэй эрдэм шинжилгээний ажилтан дараах шалгуурыг хангасан бол дахин төслийн сонгон шалгаруулалтад өрсөлдөх эрх нээгдэнэ:

1.7.1 Энэ бүлгийн 1.6-д заагдсан дээд хязгаарт хурсний дараа тодорхой хугацаа өнгөрөхөд дахин өрсөлдөх эрх нээгдэх ба энэ тохиолдолд төслөөс хүлээгдэх үр дүн нь чанарын хувьд заавал ахисан байхыг



шаардана;

- 1.7.2 Чанарын хувьд ахисан эсэх дээр хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулна.

1.8 МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургууль бие дааж дотоод төсөл зарлаж, шалгаруулах тохиолдолд Төслийн Менежментийн Мэдээллийн Систем /цаашид ТММС гэх/-д бүртгүүлнэ.

1.9 МУИС нь дараах судалгааны төсөл, тэтгэлгийг санхүүжүүлнэ. Үүнд:

- 1.9.1 судалгааны зардал;
- 1.9.2 залуу судлаачийн тэтгэлэг;
- 1.9.3 зочин судлаач, докторын дараах судалгааны тэтгэлэг;
- 1.9.4 өндөр түвшний судалгааны төсөл;
- 1.9.5 МУИС-ийн судалгааны тэргүүлэх чиглэлийн бодлогын судалгааны төсөл;
- 1.9.6 инновацийн төсөл.

1.10 МУИС-ийн судалгааны санхүүжилттэй төслийн саналын хүлээгдэж буй үр дүн 1 жилийн хугацаатай байна. Салбарын Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн 1 жил хүртэлх хугацаагаар төсөл хэрэгжүүлэх хугацааг 1 удаа сунгаж болно.

1.11 Төслийн удирдагч нь салбарын Эрдмийн зөвлөлийн хурлаар төслийн хугацаа сунгах асуудлыг хэлэлцүүлэх хүсэлтээ тухайн жилийн 12 дугаар сарын 01-ний дотор хүргүүлнэ.

1.12 Төслийн удирдагч нь төслийн хугацаа сунгасан эсэх тухай Эрдмийн зөвлөлийн шийдвэрийн цахим хувилбарыг тухайн сургуулийн холбогдох нэгжид 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлсэн байна.

1.13 Гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд санхүүжилт олгохгүй бөгөөд тухайн төслийг ТММСд амжилтгүй хэрэгжсэн төлөвт шилжүүлнэ.

1.14 МУИС-аас санхүүжиж байгаа судалгааны суурь зардал болон судалгааны төслийн санхүүжилтийн хэмжээг МУИС-ийн захиргааны зөвлөлөөс жил бүр тогтооно.

ХОЁР. Журмын нэр томьёо

2.1 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 2.1.1 “Судалгаа” гэж шинэ мэдлэг, онол арга зүй, хэрэглээ инновацийг шинжлэх ухааны үндэслэл, нотолгоотойгоор бий болгох, хөгжүүлэх, турших, хэрэгжүүлэн нэвтрүүлэхэд чиглэсэн суурь ба хэрэглээний шинжтэй эрдмийн үйл ажиллагааг;
- 2.1.2 “Суурь судалгаа” гэж байгаль, нийгэм, хүмүүнлэг, техник технологийн шинэ мэдлэг, онол аргазүйг бий болгоход чиглэсэн эрдмийн үйл ажиллагааг;
- 2.1.3 “Судалгааны үр дүн” гэж судалгааны үйл ажиллагааны хүрээнд бий болсон шинэ мэдлэг, онол аргазүй болон хэрэглээ, байгаль, нийгэм, хүмүүнлэг, техник технологийн шийдлийг;
- 2.1.4 “Эрдэм шинжилгээний төсөл” гэж нэг талаас аль нэг хуулийн этгээд захиалж, нөгөө талаас судалгааны баг гүйцэтгэлийг хариуцсан,

захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан үр дүн бий болгох зорилготой, захиалагчаас санхүүжүүлсэн бие даасан төсөвтэй, тодорхой хугацаатай гүйцэтгэхээр төлөвлөсөн судалгааны ажлыг;

- 2.1.5 "Гадаадтай хамтарсан төсөл" гэж гадаадын байгууллага, судлаачидтай судалгаа төслийг;
- 2.1.6 "Гадаад төсөлд оролцох" гэж гадаадын байгууллагын санхүүжилттэй төсөлд удирдагч, гүйцэтгэгчээр оролцохыг;
- 2.1.7 "Судалгааны суурь зардал" гэж МУИС-ийн профессор, дэд профессор, ахлах багшийн зэрэглэлд ажиллаж байгаа докторын зэрэгтэй үндсэн орон тооны багш нарын судалгааны үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгох санхүүжилтийг;
- 2.1.8 "Судалгааны хувьсах зардал" гэж ахисан түвшний суралцагчдын эрдэм шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор удирдагч багшийн удирдаж хамгаалуулсан суралцагчдын тоо, тэдгээрийн эрдэм шинжилгээний ажлын чанарын үзүүлэлтийг харгалзан тооцож олгох санхүүжилтийг;
- 2.1.9 "Лабораторийн суурь зардал" гэж Ахисан Түвшний Сургууль /цаашид ATC гэх/-д харьялагддаг МУИС-ийн судалгааны лаборатори/профессорын багуудад, ахисан түвшний суралцагчдын судалгаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор олгох санхүүжилтийг;
- 2.1.10 "Залуу судлаачийн тэтгэлэг" гэж салбар дундын хамтын ажиллагаа, хамтарсан судалгааг дэмжих, нээлттэй, дундын ашиглалттай дэд бүтцийг бүрдүүлэх, судалгааны ажил хийх дадал төлөвшүүлэх зорилгоор докторын зэрэгтэй багшид олгох тэтгэлгийг;
- 2.1.11 "Зочин судлаачийн тэтгэлэг" гэж МУИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор, ахлах багш, багш, докторын зэрэгтэй эрдэм шинжилгээний ажилтан нар судалгааны чиглэлээр гэрээ байгуулж МУИС-д 6 сар болон түүнээс дээш хугацаагаар гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас ирж, хамтран ажиллах профессорын судалгааны ажлын санхүүжилтийг;
- 2.1.12 "Өндөр түвшний судалгааны төсөл" гэж судалгааны ажлын үр дүнг Journal Citation Reports (JCR)-ын импакт фактор бүхий WoS, Scopus-д бүртгэлтэй олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх, дотоодод болон олон улсад оюуны өмчийн эрх авах зорилго бүхий үндсэн орон тооны профессор, дэд профессор, ахлах багш, багш, докторын зэрэгтэй эрдэм шинжилгээний ажилтны дэвшүүлсэн төслийг;
- 2.1.13 "МУИС-ийн судалгааны тэргүүлэх чиглэлийн бодлогын судалгааны төсөл" гэж улс орны бодлогын тулгамдсан асуудал болон хэрэгжилтийг судлан шинжилж, асуудлыг шийдвэрлэх, практикт хэрэгжихүйц бодлогын сонголтуудыг тодорхойлж, сонголтын эерэг, серөг талын нөлөөллийг үнэлж, дүгнэсэн шийдлийг хувилбарыг санал болгох төслийг;
- 2.1.14 "Инновацийн төсөл" гэж МУИС-ийн нэр дээр батлагдсан эсвэл мэдүүлсэн оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах буюу

гарааны компани үүсгэн байгуулах, лицензийн тэрээ хийх эсхүл нийгмийн инновацийг хэрэглээнд нэвтрүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг санхүүжүүлэх төслийг хэлнэ;

ГУРАВ. Судалгааны зарчим



3.1 Судалгааны үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 3.1.1 эрдмийн эрх чөлөөг дээдлэх;
- 3.1.2 шинжлэх ухааны нэгдмэл үнэт зүйтэй байх;
- 3.1.3 судалгааны ёс зүйтэй байх;
- 3.1.4 шударга өрсөлдөөнөөр шалгаруулдаг байх;
- 3.1.5 байгалийн ухаан, инженер технологи, нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухааны салбаруудад хүртээмжтэй байх;
- 3.1.6 инновацийн үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг тэгш эрхтэй, чөлөөтэй оролцуулах;
- 3.1.7 үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх инновацийн үйл ажиллагаа явуулахгүй байх;
- 3.1.8 төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад эрдэм шинжилгээний ажил, түүний шалгаруулалт нь чөлөөт өрсөлдөөнд үндэслэсэн ил тод, шударга, нээлттэй байх;
- 3.1.9 сургалт, судалгааны үр дүн нь үйлдвэрлэгчийг дэмжсэн, эдийн засаг, нийгмийн өндөр үр ашигтай байх.

**ДӨРӨВ. Профессор, дэд профессор,
доктор багш наарт судалгааны зардал олгох**

4.1 Эрдэм шинжилгээний Б цагаа бүрэн биелүүлдэг МУИС-ийн профессор, дэд профессор, докторын зэрэгтэй ахлах багшид судалгааны зардал олгоно.

4.2 Судалгааны зардалд дараах зардлууд орно:

- 4.2.1 судалгааны суурь болон хувьсах зардал;
- 4.2.2 лабораторийн суурь зардал.

4.3 Судалгааны суурь зардлыг тухайн хичээлийн жилд гарсан 01 тушаалыг үндэслэн олгоно.

4.4 Нэгж суралцагчид ногдох хувьсах зардлын нийт дүн нь тухайн суралцагчийн эрдэм шинжилгээний ажлын багц цагийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүн байна.

4.4.1 Удирдагч багшийн өмнөх хичээлийн жилд хамгаалуулсан суралцагчдын эрдэм шинжилгээний ажлын дараах үзүүлэлтүүдээс аль нэгийг харгалzan тооцож, давхардуулахгүй олгоно:

- 4.4.1.1 олон улсын хянан магадалгаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо барих зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн бол бүтнээр;
- 4.4.1.2 5-аас доошгүй улсын судлаачид оролцсон олон улсын эрдэм шинжилгээний хуралд нэгдүгээр эсвэл холбоо барих зохиогчоор аман илтгэл хэлэлцүүлсэн бол 75%;
- 4.4.1.3 мэргэжлийн түвшинд хянан магадалгаа хийгддэг дотоодын

эрдэм шинжилгээний сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо барих зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн бол 50%;

4.4.1.4 улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд нэгдүгээр эсвэл холбоо барих зохиогчоор аман илтгэл хэлэлцүүлсэн бол 25%.
1117144746

4.4.2 Хувьсах зардлыг ахисан тувшиний суралцагчдын эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаанд 4.9.1, 4.9.2, 4.9.3, 4.9.4 дэх заалтуудын төрөлд зарцуулна.

4.5 Лабораторийн суурь зардлыг "МУИС-д судалгааны лаборатори ажиллуулах журам"-ын дагуу докторант/пост-доктороос бусад үндсэн гишүүн профессорт 100%, дэд профессорт 50%, докторын зэрэгтэй ахлах багшид 30%-иар тус тус тооцож, санхүүжилтийг жил бүр МУИС-ийн захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрээр тогтооно.

4.6 Ахлах багшийн зэрэглэлд ажиллаж буй, докторын зэргээ 5 хүртэл жилийн өмнө хамгаалсан багшид судалгааны зардлыг олгоно.

4.7 Судалгааны зардлыг санхүүгийн жилээс календарийн таван жилийн өмнөх оны 01 дүгээр сарын 01-ээр 5 жилийн хугацааг тасалбар болгон тооцно.

4.8 МУИС-ийн удирдах албан тушаалд ажиллаж буй докторын зэрэгтэй багшид судалгааны зардал олгоно.

4.9 Санхүүжилтийг дараах төрлийн зардалд зарцуулна:

4.9.1 олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх;

4.9.2 ном, сурх бичиг, гарын авлага хэвлүүлэх;

4.9.3 багаж төхөөрөмжийн хучин чадлыг нэмэгдүүлэх зорилготой бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл өгүүлэл, программ хангамж худалдан авах;

4.9.4 оюутанд ажлын хөлс, тэтгэлэг олгох;

4.9.5 лабораторийн судалгаанд зарцуулах;

4.9.6 хээрийн судалгаанд зарцуулах;

4.9.7 эмпирик судалгаанд зарцуулах;

4.9.8 олон улсын хуралд оролцох, семинар, симпозиум зохион байгуулах, хурал, семинар, симпозиумд оролцох судлаачийг гадаадаас урьж ирүүлэх.

4.10 Судалгааны зардлыг профессор, багшийн цалин, ажлын хөлсөнд зарцуулахыг хориглоно.

4.11 Тухайн зардлыг олгох жилийн өмнөх хичээлийн жилд эрдэм шинжилгээний Б цагаа бүрэн биелүүлсэн профессор, дэд профессор, ахлах багшийн зэрэглэлд ажиллаж буй докторын зэрэгтэй багш нар судалгааны зардал авах хүсэлтийг ТММС-д бүртгүүлснээр эрх нь нээгдэнэ.

4.12 Судалгааны зардлын гүйцэтгэлийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар байгуулагдсан эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг хянаж, Эрдэм Шинжилгээний Мэдээллийн Систем /цаашид ЭШММС гэх/-д баталгаажуулна.

ТАВ. Залуу судлаачийн тэтгэлэг олгох

5.1 Тэтгэлгийг 45 хүртэлх насны залуу судлаач багшид санхүүжилтийг 1 удаа олгоно.

5.2 Санхүүжилтийг цалин, ажлын хөлсөнд зарцуулахыг хориглох бөгөөд дараах зүйлд зарцуулахыг зөвшөөрнө:

- 5.2.1 олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх;
- 5.2.2 олон улсад нэг сэдэвт бүтээл, ном сурх бичиг хэвлүүлэх;
- 5.2.3 багаж төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл өгүүлэл, программ хангамж худалдан авах;
- 5.2.4 оюуны өмч мэдүүлэх зардал;
- 5.2.5 төслийн судалгааны гишүүнээр ажиллаж буй оюутанд ажлын хөлс, тэтгэлэг олгох;
- 5.2.6 лабораторийн судалгаанд зарцуулах;
- 5.2.7 хээрийн судалгаанд зарцуулах;
- 5.2.8 судалгааны ажлын үр дүнгийн олон нийтэд түгээн дэлгэрүүлэх.

5.3 Санхүүжилтийг судалгааны салбар дундын шинж чанар, судалгааны нээлттэй, дундын ашиглалттай дэд бүтцийг бүрдүүлэх боломж, доктор, докторын дараах судалгааны ажлаа үр дүнд хүргэх баталгаа, судалгааны ажлын туршлага, судалгааны ажлын үр дүнгээр JCR импакт фактор бүхий олон улсын сэтгүүлд (нийгэм, хүмүүнлэгийн салбарт Scopus цахим сангийн SCImago Journal Ranking (SCR), Source Normalized Impact per Paper (SNIP) индекстэй сэтгүүл байж болно) өгүүлэл хэвлүүлэх, оюуны өмч бий болгох боломж, хамтарсан судалгаа, семинараар дамжуулан өөр шинжлэх ухаан, технологийн салбарын залуу эрдэмтэд, оюутнуудын хоорондын хамтын ажиллагаа гүнзгийрч, цаашид цогц судалгааг тогтмол хийх соёлыг төлөвшүүлэх, баг бүрдэх байдал зэргийг харгалзан олгоно.

5.4 Залуу судлаачийг дэмжих төслийн үр дүнд Импакт фактор бүхий олон улсын мэдээллийн сан (WoS, Scopus, Springer, Dimension, PubMed гэх мэт)-д бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо барих зохиогчоор өгүүлэл хэвлүүлнэ.

5.5 Импакт фактор бүхий олон улсын мэдээллийн сан (WoS, Scopus, Springer, Dimension, PubMed гэх мэт)-д бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд хэвлэхээр зөвшөөрсөн өгүүлэл, мөн МУИС-ийн нэр дээр батлуулсан оюуны өмч /патент/ыг дүйцүүлэн тооцож болно.

5.6 Залуу судлаачийн тэтгэлэг олгох төслийн саналыг жил бүр зарласан хугацаанд ТММС-д цахим хэлбэрээр мэдүүлнэ.

ЗУРГАА. Зочин судлаач, докторын дараах судалгааны тэтгэлэг (fellowship) олгох

6.1 Зочин судлаач, докторын дараах тэтгэлгийн санхүүжилтэд Монголтой холбоотой судалгаа хийдэг гадаадын иргэд ба гадаад орны их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажилладаг Монгол Улсын иргэд хамрагдах эрхтэй.

6.2 Зочин, докторын дараах судлаачийн судлаачийн тэтгэлгийн санхүүжилтийг түүнтэй хамтран ажиллах МУИС-ийн профессор багштай хийсэн гэрээгээр зохицуулах бөгөөд дараах хэлбэрээр зарцуулна:

- 6.2.1 зочин, докторын дараах судлаачийн Монгол Улсад ирэх замын зардал;
- 6.2.2 Монгол улсад судалгаа хийх судалгааны зардал;
- 6.2.3 олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл, ном сурх бичиг, монограф буюу нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх зардал;
- 6.2.4 зочин, докторын дараах судлаачийн тэтгэлэг (стипентийн хэмжээг судлаачийн судалгааны ажлын туршлага, өөрсдийнх нь санал болгож буй хэмжээ болон холбогдох бусад хүчин зүйлийг харгалзан харилцан зөвшилцэж тогтооно).

6.3 Энэхүү санхүүжилтээр зочин, докторын дараах судлаачидтай хамтран ажиллах МУИС-ийн профессор багшид нэмэгдэл цалин хөлс олгохгүй.

6.4 Зочин, докторын дараах судлаачийн судалгааны ажлын туршлага, мэдлэгийг МУИС-ийн эрдмийн хамт олонд хүртээмжтэй байх зорилгоор МУИС-ийн хичээл явагдаж байх хугацаанд урьж ажиллуулна.

6.5 Төсөл нь дараах шаардлагуудын аль нэгийг хангасан байна:

- 6.5.1 JCR импакт фактор бүхий WoS, Scopus-д бүртгэлтэй, Q1, Q2 ангиллын мэргэжлийн сэтгүүлд МУИС-ийн профессор багштай хамтран нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор өгүүлэл хэвлүүлэх; (хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) өгүүллийг үр дүнд тооцож болно);
- 6.5.2 Олон улсын хэвлэлийн (SPI) индекс бүхий монограф хэвлүүлэх;
- 6.5.3 Хамтарсан төсөл хэрэгжүүлэх.

6.6 Зочин, докторын дараах судлаач авч ажиллуулах санал хулээн авах тухай зарлах ажлыг Эрдэм шинжилгээний хэлтэс олон улсын хэмжээнд зохион байгуулна. Зочин, судлаач нь төслийн саналаа англи, эсвэл монгол хэлээр бичиж, жил бүр зарласан хугацаанд TMMC-д цахим хэлбэрээр мэдүүлэхээс гадна дараах материалын заавал хавсаргасан байна:

- 6.6.1 зочин судлаачийн анкет;
- 6.6.2 судлаачийн бүтээлийн жагсаалт;
- 6.6.3 судлаачийн ORCID iD болон, Н-индекс;
- 6.6.4 хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг.

6.7 Үнэлгээний ажлын хэсэг зочин, докторын дараах судлаачийн ирүүлсэн төслийн саналд үнэлгээ хийхдээ дор дурдсан шалгуур үзүүлэлтээр шалгаруулна:

- 6.7.1 зочин, докторын дараах судлаач нь JCR импакт фактор бүхий WoS, Scopus-д бүртгэлтэй, Q1, Q2 ангиллын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлдэг байх;
- 6.7.2 зочин судлаачийн санал болгож буй судалгааны төслийн хэрэгжих боломж, ажлын төлөвлөгөө, үр дүнгийн баталгаатай байх;
- 6.7.3 МУИС-ийн багш, суралцагчидтай хамтран ажиллах, чадавхжуулсан байх;

6.7.4 эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг цаашид тогтвортой үргэлжлүүлэх төлөвлөгөөний хүрээнд хамтарсан судалгааны төслийн санал боловсруулан хэрэгжүүлэх боломжтой байх.

**ДОЛОО. Өндөр түвшний судалгааны төслийн
санхүүжилт олгох**



7.1 Өндөр түвшний судалгааны үр дүнд JCR импакт фактор бүхий WoS, Scopus-д бүртгэлтэй, Q1, Q2 ангиллын мэргэжлийн сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо барих зохиогчоор нэг өгүүлэл хэвлүүлэх, эсвэл олон улсын хэвлэлийн (SPI) индекс бүхий монограф хэвлүүлнэ.

7.2 Өндөр түвшний судалгааны үр дүнд JCR импакт фактор бүхий WoS, Scopus-д бүртгэлтэй, Q1, Q2 ангиллын мэргэжлийн сэтгүүлд хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) өгүүлэл, төслийн судалгааны үр дүнгээр МУИС-ийн нэр дээр батлуулсан оюуны өмч (патент)-ийг дүйцүүлэн тооцож болно.

7.3 Санхүүжилтийг цалин, ажлын хөлсөнд зарцуулахыг хориглох бөгөөд дараах зүйлд зарцуулахыг зөвшөөрнө:

- 7.4.1 багаж төхөөрөмж, түүний хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл өгүүлэл, программ хангамж худалдан авах, лицензийн төлбөр;
- 7.4.2 тухайн төслийн судалгааны гишүүнээр тогтвортой ажиллаж буй магистрант, докторант, докторын дараах судлаачид ажлын хөлс, тэтгэлэг олгох;
- 7.4.3 лабораторийн судалгаанд зарцуулах;
- 7.4.4 хээрийн судалгаанд зарцуулах;
- 7.4.5 эмпирик судалгаанд зарцуулах;
- 7.4.6 өгөгдөл цуглуулахад зарцуулах;
- 7.4.7 оюуны өмч мэдүүлэх төлбөр;
- 7.4.8 олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх;
- 7.4.9 судалгааны үр дүнг нийгэм, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх.

7.4 Профессор багш, судлаачид өндөр түвшний судалгааны төслийн санал дэвшүүлэх бөгөөд хүлээгдэж буй үр дүнгээ 1 жилийн хугацаагаар тооцож тодорхой тусгах шаардлагатай.

7.5 Өндөр түвшний төслийн саналыг жил бүр зарласан хугацаанд ТММС-д цахим хэлбэрээр мэдүүлнэ.

**НАЙМ. МУИС-ийн судалгааны тэргүүлэх чиглэлийн бодлогын
судалгааны төсөл**

8.1 МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн тодорхойлсон судалгааны тэргүүлэх чиглэлийн дагуу МУИС-ийн захиргааны зөвлөлөөс судалгааны тэргүүлэх чиглэлийн бодлогын судалгааны төслийг зарлана.

8.2 МУИС-ийн судалгааны тэргүүлэх чиглэлийн бодлогын судалгааны төслийн саналыг харьялах бүтцийн нэгжээс дэвшүүлж бүрэлдэхүүн/салбар сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж эрдэм шинжилгээний хэлтэст хүргүүлнэ.

8.3 МУИС-аас санхүүжих бодлогын судалгааны төслийн сонгон шалгаруулалтын үнэлгээг Монгол улсын хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломж, нийгэм эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөтөө, их сургуулийн судалгааны тэргүүлэх чиглэлийн нийцэл ач холбогдол зэрэг асуудлыг МУИС-ийн Эрдэм шинжилгээний бодлогын зөвлөх багаар хэлэлцүүлсэн дүгнэлтийг үндэслэн сонгон шалгаруулна.

8.4 Бодлогын судалгааны төсөл нь дор дурдсан шалгуур үзүүлэлтээр шалгаруулна:

- 8.4.1 Монгол улсын хөгжлийн бодлоготой уялдсан, цаг үеийн тулгамдсан асуудлын шийдвэрлэхэд чиглэсэн байх;
- 8.4.2 бодлогын судалгааг хэрэгжүүлэх шаардлага, үндэслэлийг тодорхойлсон байх ;
- 8.4.3 орчин үеийн бодлогын судалгааны арга зүйг оновчтой тодорхойлсон байх;
- 8.4.4 бодлогын судалгааны хэлбэр, онцлог, чанар хамрах цар хүрээг тусгасан байх;
- 8.4.5 тухайн асуудлын судлагдсан байдал, олон улсын туршлагыг тодорхойлсон байх;
- 8.4.6 судалгааны үр дүнгийн талаарх төсөөлөл, үр дүнг ашигласнаар бий болох үр дагавар, нөлөөллийг тодорхойлох;
- 8.4.7 тухайн салбарын судалгаа шинжилгээний ажлын туршлагатай эрдэмтэн судлаачдаас судалгааны багийн гишүүд бүрдсэн байх;
- 8.4.8 үр дүнг нэвтрүүлэх, ашиглах чиглэлийг тодорхойлсон байх.

8.5 Бодлогын судалгааны төслийн санхүүжилтийн зардлыг дор дурдсан хэлбэрээр захиран зарцуулна:

- 8.5.1 судалгааны материал, ном сурх бичиг, мэргэжлийн сэтгүүл, өгүүлэл, программ хангамж худалдан авах;
- 8.5.2 Өгөгдөл цуглуулах зардал;
- 8.5.3 хэлэлцүүлэг, семинар, зохион байгуулах үйл ажиллагааны зардал;
- 8.5.4 бичиг хэргийн зардал;
- 8.5.5 төслийн судалгааны гишүүнээр ажиллаж буй МУИС-ийн магистрант, докторант, докторын дараах судлаачид тэтгэлэг олгох;
- 8.5.6 судалгааны тайлан, үр дүнг хэвлүүлэх зардал;
- 8.5.7 судалгааны үр дүнг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зардал.

8.6 Төслийн үр дүнд хүлээлгэн өгөх бодлогын судалгааны тайлан нь дараах шаардлагыг хангасан байна:

- 8.6.1 бодлогын тулгамдсан асуудлыг тодорхойлж хөндсөн, нарийвчлан судалсан байх;
- 8.6.2 судалгааны аргуудыг үр дүнтэй хэрэглэсэн байх;
- 8.6.3 тухайн асуудлыг шийдвэрлэх боломжтой арга замуудыг тодорхойлсон байх;
- 8.6.4 боломжит үр дүнг шинжилгээнд түшиглэн үнэлж, танилцуулсан байх;
- 8.6.5 бодлогын шийдлийн хамгийн сайн хувилбар гэдгийг үндэслэлтэйгээр нотолсон байх;

- 8.6.6 судалгааны ажлын тайланг стандартын дагуу бичиж гүйцэтгэсэн байх;
- 8.6.7 нэр томъёоны тодорхойлолтыг хоёрдмол утtagүй, товч, оновчтой илэрхийлсэн байх.

ЕС. Инновацийн төсөл



9.1 МУИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор, докторын зэрэгтэй багш, эрдэм шинжилгээний ажилтан нар харьяалах Эрдмийн зөвлөлийн шийдвэрийн үндсэн дээр төслийн шалгаруулалтад оролцох эрх нээгднэ.

9.2 Бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөлийн шийдвэрийг төслийг зарласан хугацаанд Инноваци, технологи дамжуулах төвд цахим хэлбэрээр ирүүлнэ.

9.3 Инновацийн төсөл хэрэгжүүлэхэд дор дурдсан дараах шаардлагын аль нэгийг биелүүлсэн байна:

- 9.3.1 технологийн инновацийн төслийн удирдагч нь батлагдсан эсвэл мэдүүлсэн оюуны өмчийн зохиогч байх, тус оюуны өмчийг МУИС эзэмшдэг байх;
- 9.3.2 нийгмийн инновацийг хэрэгжүүлэхээр төслийн удирдагч болон багийн гишүүдийн санаачилсан сүүлийн 3 жилийн гүйцэтгэсэн ажлын үр дүнгийн нийгэм эдийн засагт нэмэр оруулсан байх;
- 9.3.3 нийгмийн инноваци, гарааны компанийн үйл ажиллагааг хөгжүүлэх чиглэл бүхий төслийн хувьд төслийн багийн гишүүдийн сүүлийн 5 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн бүтээлийн жагсаалт, мөн төсөл гаргах.

9.4 Төслийн саналыг зарласан хугацаанд ТММС-ийн "Инновацийн төсөл" хэсэгт бүртгүүлсэн байх ба зохих мэдээллээ бүрэн оруулсан төслүүдийг сонгон шалгаруулалтад оролцуулна.

9.5 Инновацийн төслийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд Инноваци, технологи дамжуулах төв хяналт тавина.

9.6 Инновацийн төслийн үр дүнд гарааны компани, технологийн лицензийн гэрээ байгуулагдсан, нийгмийн инновацийн шийдэл нь хэрэглээнд нэвтрэсэн байна.

АРАВ. Төслийн сонгон шалгаруулалт, тайлан

10.1 МУИС-аас санхүүжих судалгааны төсөл, тэтгэлэгт хөтөлбөрүүдийг хичээлийн шинэ жилийн эхний сард зарлаж (9 дүгээр сарын 1-ээс 10 дугаар сарын 1-ний өдөр), сонгон шалгаруулалтыг дараагийн нэг сарын хугацаанд хийн, шалгарсан төслүүдийн гэрээг 12 дугаар сарын 01-ний өдрөөс 20-ны өдрийн дотор байгуулж, үргэлжлэх хугацааг санхүүгийн жилээр тооцно.

10.2 МУИС-аас санхүүжих судалгааны төсөл, тэтгэлэгт хөтөлбөрүүдийг холбогдох мэргэжлийн шинжээчдээс бүрдсэн сонгон шалгаруулах ажлын хэсгийг төслийн төрөл бүрээр Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгж зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/349 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Шинжээчийн жагсаалт шинэчлэн батлах тухай" журам болон МУИС-ийн Захирлын 2021 оны 11

дүгээр сарын 25-ны өдрийн А/347 тоот тушаалаар баталсан “МУИС-аас санхүүжих дотоод төслийн саналд үнэлгээ хийх ажлын удирдамж”-ийн дагуу явуулна. Сонгон шалгаруулалтыг төсөл хүлээн авсан эцсийн хугацаанаас хойш 4 долбо хоногийн дотор зохион байгуулна.

10.3 Өндөр түвшний судалгааны төсөл болон залуу судлаачийн судалгааны тэтгэлгийн санхүүжилтийг шинээр эхлэх судалгаанд биш, тодорхой түвшинд хүртэл хийгдээд, анхдагч үр дүн гарсан судалгааны ажлыг дэмжих чиглэлд зарцуулахыг илүүд үзнэ.

10.4 МУИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор, докторын зэрэгтэй багш, эрдэм шинжилгээний ажилтан нь өндөр түвшний судалгааны төсөл, залуу судлаачдын багийн тэтгэлэг, бодлогын судалгаа, инновацийн төсөлд удирдагч, эсвэл гүйцэтгэгчээр жилд нэг төсөлд зөвхөн 1 удаа оролцно.

10.5 Бүх төрлийн төслийн санхүүжилтийн гэрээг Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгж болон Санхүү, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн удирдлагатай байгуулна.

10.6 Төслийн удирдагч гэрээ байгуулагдсаны дараа төслөө ТММС-д бүртгүүлснээр төслийн санхүүжилтийг зарцуулах эрх нээгдэнэ. Төслийн санхүүгийн зарцуулалтыг хийхдээ гүйлгээний утга хэсэгт тухайн төслийн кодыг заавал бичнэ.

10.7 Эрдэм шинжилгээний Б цагийн гүйцэтгэлтэй холбогдуулан эрдэм шинжилгээ менежментийн мэдээллийн системд МУИС-аас санхүүжих төслийн мэдээллийг зөвхөн төслийн удирдагч мэдүүлэх бөгөөд тухайн төслийн гишүүдийг бүрэн оруулах үүрэгтэй.

10.8 Судалгааны төсөл, тэтгэлгийн удирдагч нь судалгааны гүйцэтгэл ба санхүүгийн зарцуулалтаа улирлаар ТММС-д оруулна. Эрдэм шинжилгээний хэлтэс, Санхүү, төлөвлөлтийн газар хагас жилээр системийн өгөгдлийг хянаж баталгаажуулна. Судалгааны төсөл, тэтгэлгийн удирдагч нь эцсийн тайлангаа салбарын эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсний үндсэн дээр ТММС-д эцсийн судалгааны тайлан, санхүүгийн тайлан, үр дүнгийн баталгаажуулалтаа 12 дугаар сарын 25-ны дотор оруулна. Эрдэм шинжилгээний хэлтэс нь салбарын эрдмийн зөвлөлийн протокол, үр дүнгийн баталгаажуулалт, тайланг хянан магадлан төслийг хаана.

10.9 Сонгон шалгаруулалтын үнэлгээгээр төслийн санал нь шалгарсан төслийн удирдагч нь тухайн төслийг хэрэгжүүлэхээс татгалзах нөхцөлд тухайн төслийн саналд үнэлгээ хийсэн шинжээчдийн ажлын хөлсийг нэхэмжилсэн үнийн дүнгээр төлж барагдуулна.

10.10 Төслийн сонгон шалгаруулалт, хэрэгжилт, үр дүнтэй холбоотой ямар нэг хүсэлт, гомдол, маргааныг холбогдох нэгжид бичгээр ирүүлэх бөгөөд тус гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан хариуг хүргүүлнэ.

10.11 МУИС-ийн судалгааны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дунд бий болох оюуны өмчийн эрх эзэмшигч нь МУИС байх ба хэрэв төсөл хэрэгжүүлэгч, эсвэл төсөлд хамтрагч гуравдагч талаас оюуны өмчийн эрх эзэмшилтэй холбоотой санал, хүсэлт гарсан тохиолдолд тухай бүр Инноваци, технологи дамжуулах төвд мэдэгдэж, Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгжийн удирдлага зохих шийдвэрийг гаргана.

АРВАН НЭГ. Төслийн үр дүнг түгээх

11.1 Бүх төрлийн төсөл, тэтгэлгийн судалгааны үр дүнгийн тайлан, өгүүлэл хэвлүүлсэн сэтгүүлийн мэдээллийг эрдэм шинжилгээний мэдээллийн менежментийн системд оруулна.

11.2 Гүйцэтгэгч төслийн үр дүнг хэвлэн нийтлүүлэх, эрдэм шинжилгээний хуралд илтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернетээр мэдээлж түгээх, сурталчлахдаа МУИС-ийн судалгааны санхүүжилтийн ямар төрлөөр санхүүжүүлсэн болохыг төслийн дугаарыг хамт заавал дурдана.

АРВАН ХОЁР. Хүлээлгэх хариуцлага

12.1 Төслийн гэрээний хугацаа дуусгавар болоход төслийн үр дүн болон тайланг ТММС-д оруулаагүй, салбарын Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж үр дүнг хүлээлгэн өгөөгүй нөхцөлд дор дурдсан хариуцлага хүлээнэ:

12.1.1 төслийн тайланг журмын заасан хугацаанд ТММС-д оруулаагүй болон гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд МУИС-ийн судалгааны санхүүжилт дахин олгохгүй;

12.1.2 төслийн гэрээний үүргээ биелүүлээгүй төслийн удирдагч төслийн гэрээнд заасны дагуу төслийн санхүүжилтийг 100% буцаан төлж барагдуулна;

12.1.3 төслийн үр дүнд хэвлүүлсэн бүтээлд тухайн төслийн удирдагчийн нэр, МУИС-ийн судалгааны санхүүжилтийн мэдээлэл болон төслийн дугаарыг дурдаагүй нөхцөлд төслийн санхүүжилтийн дүнгээр буцаан төлнө;

12.1.4 төслийн гүйцэтгэлийн явцад санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар удаашрах, үр дүн нь гэрээнд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд Эрдэм шинжилгээний хэлтсийн хугацаанаас нь өмнө гэрээг цуцлах, санхүүжүүлсэн дүнгийн хэмжээг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх талаар Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгж болон Санхүү, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн удирдлагад санал тавьж шийдвэрлүүлнэ;

12.2 Гүйцэтгэгч нь төслийн үр дүн болон судалгааны ажлыг гүйцэтгэх явцад судалгааны ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан Судлаачийн ёс зүйн журам, МУИС-ийн ёс зүйн журмын дагуу шийдвэрлэнэ.

АРВАН ГУРАВ. Бусад

13.1 Төслийн удирдагч нь судалгааг гүйцэтгэх хугацаанд ирээдүйд бий болох эрсдэл, давагдашгүй хүчин зүйлээс үүсэх үр дагаврын холбогдох нөхцөлийг гэрээний Хавсралтаар батлуулж төслийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төслийн багийн гишүүнийг томилно.

13.2 Төслийн багийн гишүүн зөвшөөрсөн тохиолдолд төслийн удирдагч төслийн гэрээг багийн гишүүнд шилжүүлж болно.